

**НУТАГ ДЭВСГЭР ХАРИУЦСАН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАСАГ, ХЭСГИЙН
ДАРГЫН АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2024.02.07

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 2.1.2, 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тасаг, хэсгийн даргын албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж, зарыг алба хаагчдад хүргэж байна.

**ТУСГАЙ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	Алба, нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Цолны зэрэглэл	Цалингийн зэрэглэл
Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тасгийн дарга				
1	Арханхангай аймгийн цагдаагийн газар	Эрдэнэмандал сумын сум дундын цагдаагийн тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
2	Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
3	Баянхонгор аймгийн цагдаагийн газар	Бууцагаан сумын сум дундын цагдаагийн тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
4	Дундговь аймгийн цагдаагийн газар	Мөрдөн байцаах тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-4
5	Хэнтий аймгийн цагдаагийн газар	Жаргалтхаан сумын сум дундын цагдаагийн тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэсгийн дарга				
6	Дорноговь аймгийн цагдаагийн газрын Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэс	Шуурхай удирдлагын хэсгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
7	Увс аймгийн цагдаагийн газар	Өндөрхангай сумын сум дундын цагдаагийн хэсгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-5
8	Хэнтий аймгийн цагдаагийн газар	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ-4

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

Нэг.Дараах болзол, шаардлагыг хангасан цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагч шалгалтад бүртгүүлнэ. Үүнд:

1.1.НУТАГ ДЭВСГЭР ХАРИУЦСАН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАСАГ, ХЭСГИЙН ДАРГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	-Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, -Аюулгүй байдлыг хангахад ангилагдаагүй чиглэл /1039/, -Эрх зүй /042101/,
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх /2022, 2023, 2024 оны “Албан тушаалд шатлан дэвшүүлэх нөөц”-ийн “нэгжийн тасаг, хэсгийн дарга”-ын нөөцөд бүртгэгдсэн ба 2022, 2023, 2024 оны нөөцөд бүртгэгдсэн бол албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх/
Туршлага	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил, үүнээс ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
Бусад	Ял, сахилгын шийтгэлгүй байх Албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадварын шаардлагыг хангаж байх

Хоёр. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

-Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт; /pdf/

-Оролцогчийн танилцуулга; /pdf/

-Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг; /pdf/

Тайлбар:

-Дээр дурдсан баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан алба хаагч өөрөө хариуцна.

-Хэрвээ хуурамч, дутуу баримт бичиг бүрдүүлэн төрийн албаны тусгай шалгалтад бүртгүүлсэн, оролцсон, нэр дэвшсэн, албан тушаалд томилогдсон нь тогтоогдсон нөхцөлд үүнээс үүдэн гарах хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.

-Шалгалт зохион байгуулах комисс шаардлагатай гэж үзвэл нэмэлт материал шаардах эрхтэй болохыг анхаарна уу.

-Дээрх бүрдүүлбэрийн дэс дарааллын дагуу файлуудаа нэгтгэн (pdf, rar, zip) 1 файл болгон энэхүү зард заасан цахим шууданд ирүүлнэ үү.

Гурав. Бүртгэлийн ажиллагаа

Сонгон шалгаруулалтын комисс албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох алба хаагчийн хүсэлт, холбогдох баримт бичгийг 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 15 цагаас 02 дугаар сарын 13-ны өдрийн 15:00 цагийн хооронд /Олзбаяр.Б д/х ЦЕГ, ЗУГ, ХНХ outlook/ хаягаар цахимаар хүлээн авна.

Бүртгүүлэхээр ирүүлсэн алба хаагчийн хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрэн болон тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг комисс нягтлан шалгаад бүртгэх эсэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа хэлэлцэн гаргах ба бүртгээгүй бол энэ тухай шалтгааныг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ӨРСӨЛДӨХ
АЛБА ХААГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Овог:
2. Нэр:
3. Төрсөн огноо:
4. Хүйс:
5. Төрсөн хот, аймаг, сум:
6. Одоогийн харьяалал, оршин суугаа хаяг:
7. Регистр:
8. Боловсрол:
9. Мэргэжил:
10. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажиллаж байсан газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1.			
2.			
3.			

11. Улсад ажилласан нийт хугацаа ___ жил, үүнээс цагдаагийн байгууллагад ___ жил, ахлах албан тушаалд ___ жил

12. Шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		

13. Сахилгын шийтгэл:

14. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ /Сүүлийн 3 удаа/:

15. Албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдсэн огноо:

---oOo---